ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын Засаг даргын Тамгын газар 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

**Аудитын код:** ХӨА-2022/110/НА-СТА-ТШЗ


Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ
Утас: 99900662 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Отгонбаяр
Утас: 89306788 Цахим хаяг: otgonbayarde@audit.gov.mn


Цахим хуудас: www.audit.mn
Хөвсгөл аймаг
2022 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт ..... 2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ..... 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 10
3. Аудитын тайлан ..... 10
3.1 Ерөнхий зүйл ..... 10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ..... 10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..... 11
3.4 Материаллаг байдал ..... 11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ..... 11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ..... 12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ..... 13
3.8 Аудитын гол асуудал ..... 13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ..... 14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... 14
4. Аудитын илрүүлэлт ..... 14
4.1 Залруулсан алдаа ..... 14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ..... 15

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |
| ЗГНХ | Засгийн газрын нөөц хөрөнгө |
| ЗДНХ | Засаг даргын нөөц хөрөнгө |
| НА | Нягтлах ажил |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ИТХ | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

67120. Хөвсгөл аймаг. Мөрөн сум
ЗДТГ-ын А корпус 3 давхар, Утас,факс: 70-38 37-93
Э-майл: khuvsgul@audit.gov.mn
Вэбсайт: www.audit.mn

2022.02.23 № 01/110
танай ____________ -ны № ____________ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН УЛААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА М.БАТЦОГТ ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **19,007,048.00** | **12,276,178.00** |
| **33** | **АВЛАГА** | 5,511,370.00 | 105,000.00 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 00.00 | 105,000.00 |
| **335** | **Бусад авлага** | 5,511,370.00 | 00.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 5,511,370.00 | 00.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 13,495,678.00 | 12,171,178.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 9,995,678.00 | 8,671,178.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 201,678.00 | 197,178.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 4,064,000.00 | 4,064,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 4,400,000.00 | 1,980,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 1,330,000.00 | 2,430,000.00 |
| 35600 | Мал амьтад | 3,500,000.00 | 3,500,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,400,428,905.32** | **1,419,214,939.10** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,400,428,905.32 | 1,419,214,939.10 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,317,553,786.78 | 1,335,979,820.60 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,117,111,598.01 | 1,144,591,598.01 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -101,824,272.43 | -141,383,420.55 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 317,574,800.00 | 316,034,800.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -189,491,023.37 | -226,191,054.50 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 176,021,245.00 | 169,575,602.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -115,546,282.91 | -113,730,746.40 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 14,287,247.00 | 20,324,973.33 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -8,240,007.43 | -6,995,372.91 |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 15,000,000.00 | 15,000,000.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 215,893,755.00 | 276,935,795.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -123,233,272.09 | -118,182,353.38 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 82,875,118.54 | 83,235,118.50 |
| 39301 | Програм хангамж | 1,632,000.00 | 2,132,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,002,000.02 | -1,142,000.06 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 83,625,118.56 | 82,245,118.56 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | -1,380,000.00 | 00.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,419,435,953.32** | **1,431,491,117.10** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **5,511,370.00** | **00.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 5,511,370.00 | 00.00 |
| **413** | **Өглөг** | 5,511,370.00 | 00.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 5,511,370.00 | 00.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 5,511,370.00 | 00.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,413,924,583.32** | **1,431,491,117.10** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,413,924,583.32 | 1,431,491,117.10 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 582,884,805.97 | 582,884,805.97 |
| 51101 | Өмч: - төрийн | 582,884,805.97 | 582,884,805.97 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 335,861,301.19 | 353,805,834.97 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 335,861,301.19 | 330,727,931.19 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 23,077,903.78 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 495,178,476.16 | 494,800,476.16 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,419,435,953.32** | **1,431,491,117.10** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **538,237,532.00** | **587,068,225.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **114,634,948.00** | **151,522,758.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 114,634,948.00 | 151,522,758.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 114,634,948.00 | 151,522,758.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 114,634,948.00 | 151,522,758.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **423,602,584.00** | **435,545,467.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 6,814,584.00 | 11,077,167.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 550,000.00 | 00.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 2,500,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,099,184.00 | 1,287,217.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,165,400.00 | 7,289,950.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 416,788,000.00 | 424,468,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 416,788,000.00 | 424,468,300.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **537,633,326.97** | **563,990,321.22** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **537,633,326.97** | **563,990,321.22** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 513,640,609.97 | 561,863,899.22 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 250,642,161.00 | 253,030,000.00 |
| 210101 | Үндсэн цалин | 225,196,561.00 | 187,200,000.00 |
| 210102 | Нэмэгдэл | 00.00 | 40,630,000.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 25,445,600.00 | 25,200,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 34,848,600.00 | 34,159,100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 24,560,900.00 | 24,037,900.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,571,900.00 | 2,530,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,057,500.00 | 2,024,200.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 514,400.00 | 506,100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,143,900.00 | 5,060,600.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 20,878,823.00 | 21,920,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,603,823.00 | 4,500,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 16,775,000.00 | 16,920,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 500,000.00 | 500,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 69,863,640.20 | 47,280,180.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,800,000.00 | 4,641,180.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 28,821,800.00 | 27,323,100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,820,000.00 | 3,000,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 800,000.00 | 799,600.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,119,600.00 | 2,496,350.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,800,000.00 | 9,019,950.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 25,702,240.20 | 00.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 2,460,000.00 | 1,500,000.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 960,000.00 | 00.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,500,000.00 | 1,500,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6,935,200.00 | 18,761,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 6,935,200.00 | 18,761,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,626,600.00 | 2,600,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,626,600.00 | 2,600,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 11,755,383.00 | 21,330,465.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 10,229,384.00 | 19,003,517.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 200,000.00 | 329,286.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 118,200.00 | 270,714.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 183,794.00 | 201,948.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 50,000.00 | 75,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 650,000.00 | 650,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 324,005.00 | 800,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 113,630,202.77 | 161,283,154.22 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 20,922,200.00 | 23,636,830.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,499,000.00 | 1,500,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 90,209,002.77 | 136,146,324.22 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 23,992,717.00 | 2,126,422.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 14,177,000.00 | 2,000,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 11,177,000.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,000,000.00 | 2,000,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 9,815,717.00 | 126,422.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 9,815,717.00 | 126,422.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **604,205.03** | **23,077,903.78** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **604,205.03** | **23,077,903.78** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан / төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C08 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **582,884,805.97** | **495,178,476.16** | **335,861,301.19** | 1,413,924,583.32 |
| D01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **582,884,805.97** | **495,178,476.16** | **335,861,301.19** | 1,413,924,583.32 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | -5,133,370.00 | -5,133,370.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **582,884,805.97** | **495,178,476.16** | **330,727,931.19** | 1,408,791,213.32 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -378,000.00 | 00.00 | -378,000.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 23,077,903.78 | 23,077,903.78 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **582,884,805.97** | **494,800,476.16** | **353,805,834.97** | 1,431,491,117.10 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан / төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | **423,701,584.00** | **435,545,467.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **423,701,584.00** | **435,545,467.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 99,000.00 | 00.00 |
| 131003 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 99,000.00 | 00.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 6,814,584.00 | 11,077,167.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 550,000.00 | 00.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 2,500,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,099,184.00 | 1,287,217.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,165,400.00 | 7,289,950.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 416,788,000.00 | 424,468,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 416,788,000.00 | 424,468,300.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **416,491,584.00** | **432,135,867.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **416,491,584.00** | **432,135,867.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **392,498,867.00** | **430,009,445.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 250,642,161.00 | 253,030,000.00 |
| 210101 | Үндсэн цалин | 225,196,561.00 | 187,200,000.00 |
| 210102 | Нэмэгдэл | 00.00 | 40,630,000.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 25,445,600.00 | 25,200,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 34,848,600.00 | 34,159,100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 24,560,900.00 | 24,037,900.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,571,900.00 | 2,530,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,057,500.00 | 2,024,200.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 514,400.00 | 506,100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,143,900.00 | 5,060,600.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 16,603,823.00 | 19,500,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,603,823.00 | 4,500,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 12,500,000.00 | 14,500,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 500,000.00 | 500,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 44,165,900.00 | 47,380,680.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,800,000.00 | 4,741,680.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 28,826,300.00 | 27,323,100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,820,000.00 | 3,000,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 800,000.00 | 799,600.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,119,600.00 | 2,496,350.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,800,000.00 | 9,019,950.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 1,500,000.00 | 1,500,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,500,000.00 | 1,500,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6,935,200.00 | 19,861,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 6,935,200.00 | 19,861,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,626,600.00 | 2,600,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,626,600.00 | 2,600,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 11,755,383.00 | 21,330,465.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 10,229,384.00 | 19,003,517.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 200,000.00 | 329,286.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 118,200.00 | 270,714.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 183,794.00 | 201,948.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 50,000.00 | 75,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 650,000.00 | 650,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 324,005.00 | 800,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 23,421,200.00 | 30,648,200.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 20,922,200.00 | 29,148,200.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,499,000.00 | 1,500,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **23,992,717.00** | **2,126,422.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 14,177,000.00 | 2,000,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 11,177,000.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,000,000.00 | 2,000,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 9,815,717.00 | 126,422.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 9,815,717.00 | 126,422.00 |
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **7,210,000.00** | **3,409,600.00** |
| 5 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **7,210,000.00** | **3,409,600.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **7,210,000.00** | **3,409,600.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 7,210,000.00 | 3,409,600.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 7,210,000.00 | 3,409,600.00 |
| 6 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-7,210,000.00** | **-3,409,600.00** |
| 7 | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| 1 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 424468300.0 | 424446878.0 | -21422.0 | 100.0 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 424,468,300.0 | 424,446,878.0 | -21422.0 | 100.0 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 422,468,300.0 | 422,446,878.0 | -21422.0 | 100.0 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 253,030,000.0 | 253,030,000.0 | 0.0 | 100.0 |
| 210101 | Үндсэн цалин | 187,200,000.0 | 187,200,000.0 | 0.0 | 100.0 |
| 210102 | Нэмэгдэл | 40,630,000.0 | 40,630,000.0 | 0.0 | 100.0 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 25,200,000.0 | 25,200,000.0 | 0.0 | 100.0 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 34,159,100.0 | 34,159,100.0 | 0.0 | 100.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 24,037,900.0 | 24,037,900.0 | 0.0 | 100.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,530,300.0 | 2,530,300.0 | 0.0 | 100.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,024,200.0 | 2,024,200.0 | 0.0 | 100.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 506,100.0 | 506,100.0 | 0.0 | 100.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,060,600.0 | | 0.0 | 100.0 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 19,500,000.0 | 19,500,000.0 | 0.0 | 100.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,500,000.0 | 4,500,000.0 | 0.0 | 100.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210302 | Түлш, халаалт | 14,500,000.0 | 14,500,000.0 | 0.0 | 100.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 500,000.0 | 500,000.0 | 0.0 | 100.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 42,923,100.0 | 42,915,730.0 | -7370.0 | 100.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,500,000.0 | 4,496,680.0 | -3320.0 | 99.9 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 27,323,100.0 | 27,323,100.0 | 0.0 | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,000,000.0 | 3,000,000.0 | 0.0 | 100.0 |
| 210404 | Ном, хэвлэл | 800,000.0 | 799,600.0 | -400.0 | 100.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,500,000.0 | 2,496,350.0 | -3650.0 | 99.9 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,800,000.0 | 4,800,000.0 | 0.0 | 100.0 |
| **2105** | **Нормативт зардал** | 1,500,000.0 | 1,500,000.0 | 0.0 | 100.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,500,000.0 | 1,500,000.0 | 0.0 | 100.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 22,581,600.0 | 22,570,600.0 | -11000.0 | 100.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,709,600.0 | 2,709,600.0 | 0.0 | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 19,872,000.0 | 19,861,000.0 | -11000.0 | 99.9 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,600,000.0 | 2,600,000.0 | 0.0 | 100.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,600,000.0 | 2,600,000.0 | 0.0 | 100.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 15,526,300.0 | 15,523,248.0 | -3052.0 | 100.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 13,196,300.0 | 13,196,300.0 | 0.0 | 100.0 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 400,000.0 | 329,286.0 | -70714.0 | 82.3 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 200,000.0 | 270,714.0 | 70714.0 | 135.4 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 200,000.0 | 201,948.0 | 1948.0 | 101.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 80,000.0 | 75,000.0 | -5000.0 | 93.8 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 650,000.0 | 650,000.0 | 0.0 | 100.0 |
| 210807 | Газрын төлбөр | 800,000.0 | 800,000.0 | 0.0 | 100.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 30,648,200.0 | 30,648,200.0 | 0.0 | 100.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 29,148,200.0 | 29,148,200.0 | 0.0 | 100.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,500,000.0 | 1,500,000.0 | 0.0 | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 2,000,000.0 | 2,000,000.0 | 0.0 | 100.0 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 2,000,000.0 | 2,000,000.0 | 0.0 | 100.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,000,000.0 | 2,000,000.0 | 0.0 | 100.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 424468300.0 | 424446878.0 | -21422.0 | 100.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 424468300.0 | 424446878.0 | -21422.0 | 100.0 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 424468300.0 | 424446878.0 | -21422.0 | 100.0 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 26.0 | 26.0 | 0.0 | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 3.0 | 3.0 | 0.0 | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 17.0 | 17.0 | 0.0 | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 2.0 | 2.0 | 0.0 | 100.0 |
| 620004 | Гэрээт ажилтан | 4.0 | 4.0 | 0.0 | 100.0 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **26.0** | **26.0** | 0.0 | 100.0 |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 9.0 | 9.0 | 0.0 | 100.0 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 6.0 | 6.0 | 0.0 | 100.0 |
| 650010 | Гэрээт ажилтан | 4.0 | 4.0 | 0.0 | 100.0 |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 7.0 | 7.0 | 0.0 | 100.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **11,077,167.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **11,077,167.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 11,077,167.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | 4,569,950.00 |
| 210401 | Бичиг хэрэг | | 245,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 4,219,950.00 |
| 213403 | Төвлөрүүлэн шилжүүлэг /Орон нутаг/ | | 105,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | 700,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 700,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | 5,807,217.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 5,807,217.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 0.00 | 11077167.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 11,077,167.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 2,500,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 1,287,217.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 7,289,950.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бухий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд Улаан-уул сумын Засаг даргын Тамгын газрын төсвийг бодитой төлөвлөж, захиран зарцуулах, шилэн дансны нэгдсэн хуудаст мэдээлэл байршуулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Отгонбаяр, гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 11/16 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын Засаг даргын Тамгын газар нь стратегийн төлөвлөгөө, бодлогын удирдамжийн хэрэгжилт, хөтөлбөр, төслийн биелэлт зэргийг сумын Засаг даргын дэргэдэх тасаг, алба, албан байгууллага, аж ахуйн нэгжид хэрхэн хэрэгжиж байгааг хянах, шалгах, зохицуулах, чиглэл өгөх, мэдээлэл авах зэрэг эрхтэйгээс гадна дээрх байгууллагаар дамжуулан мэдээллийг цуглуулж хяналт шинжилгээ хийх дүгнэлт гаргах үүрэгтэй ажилладаг орон нутгийн төсвийн байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Нийгмийн даатгалын тухай хуульд заасан шимтгэлийн хувь хэмжээнд өөрчлөлт орж, Монгол Улсын засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 2021 оны 43-р тогтоол, "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг шинэчлэх тухай” Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал батлагдаж гарсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллага нь Аймгийн Засаг даргын 2019 оны А/375 тоот захирамжаар баталсан бодлогын баримт бичгийг мөрдөж байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 494.9 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 6.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 5.0 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 12.1 сая төгрөгөөр буюу 0.9 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | | |
| Авлага | 5,5 | 0,1 | (5.4) |
| Урьдчилгаа | | | - |
| Бараа материал | 13,5 | 12,2 | (1.3) |
| Үндсэн хөрөнгө | 1.400.4 | 1.419.2 | 18.8 |
| **Нийт хөрөнгө** | 1.419.4 | 1.431.5 | 12.1 |
| Өр төлбөр | 5.5 | 0.0 | (5.5) |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1.413.9 | 1.431.5 | 12.1 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 1,419.4 | 1,431.5 | 12.1 |

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх он болон тайлант онд үлдэгдэлгүй байна.
Авлага дансны эцсийн үлдэгдэл эхний үлдэгдлээс 5.5 сая төгрөгөөр буурч үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 12.2 сая төгрөг болж (1.3) сая төгрөгөөр буурсан нь 2021 онд ойн гоожин нэмэгдэж 1метр куб модны үнэ урд оноос нэг дахин өссөнтэй холбоотой түлш халаалтын түлшний модны нөөц буурсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,431.5 сая төгрөг болж 12.1 сая төгрөгөөр өссөн байна . Үндсэн хөрөнгийн данс нь үнэ төлбөргүй хүлээн авсан 151.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, урсгал төсвийн худалдан авсан 3.4 сая төгрөг нэмэгдэж. тайлант үеийн элэгдлийн зардал 136.1 сая төгрөгөөр хасагдсан байна. Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 56.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хассан байна.

Өр төлбөр дансны эхний үлдэгдэл 5.5 сая төгрөг байснаас, 5.5 сая төгрөгөөр буурч тайланд онд өр төлбөргүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,431.5 сая төгрөг болж, тайлант үеийн үр дүн 12.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тайлант онд Улаан-Уул сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 5 дугаар тогтоолоор Төсөв захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр анх 380.2 сая төгрөгийн төсөв баталсан.

Улаан-Уул сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 8 дүгээр сарын 27-ны өдрийн 07 дугаар тогтоолоор 44.3 сая төгрөгөөр нэмэх тодотгол хийж 424.5 сая төгрөгийн төсөв батлагдсан.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 424.46 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 424.44 сая төгрөгийг зарцуулж 0.02 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 424.4 сая төгрөг буюу 99.99 хувьтай байна.

Тухайн байгууллагын төсвийн гүйцэтгэлийг хөтөлбөр, арга хэмжээгээр харуулбал:

*Хүснэгт 2.* Төсвийн гүйцэтгэл хөтөлбөр, арга хэмжээгээр

/сая.төгрөг/

| № | Хөтөлбөрийн код, нэр | Арга хэмжээний код, нэр | Зардлын дүн | | Зөрүү |
|---|---|---|---|---|---|
| | | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | |
| 1 | 70106 Орон нутгийн гүйцэтгэх удирдлага | 80101 Үндсэн үйл ажиллагаа | 307.2 | 307.1 | 00.2 |
| | | 80103 Гэрээгээр гүйцэтгэх ажил үйлчилгээний зардал | 28.6 | 28.6 | 0.0 |
| | | 80106 Баг хорооны үйл ажиллагааны зардал | 54.5 | 54.5 | 0.0 |
| | | 80305 Биеийн тамирын уралдаан, тэмцээн | 2.0 | 2.0 | 0.0 |
| | | 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж | 2.0 | 2.0 | 0.0 |
| | | 82801 Улсын баяр наадмын зардал | - | - | - |
| | | 81102 Орон нутгийн нөөц хөрөнгө | 17.0 | 17.0 | 0.0 |
| 2 | 71413 байгаль орчин хамгаалан нөхөн сэргээх | 81701 Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардал | 13.2 | 13.2 | 0.0 |
| **Нийт дүн** | | | **424.46** | **424.44** | **00.2** |

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр дээд шатны төсөв захирагчаас 3.7 сая төгрөг, төрийн болон орон нутгийн өмчит бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс 3.3 сая төгрөгийн хандив тусламж, Төсөвт байгууллагын туслах үйл ажиллагааны орлого 4.0 сая төгрөг нийт 11.0 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Үүнээс хангамжийн бараа материалын зардалд 4.5 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжид 5.8 сая төгрөг, Багаж тоног төхөөрөмжийн зардалд 0.7 сая төгрөг нийт 11.0 сая төгрөг зарцуулжээ.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд тусгагдаагүй онцлог үйл ажиллагааг харуулбал. Үүнд:

- Улаан-Уул сумын Засаг даргын тамгын газар нь төр, эдийн засаг, нийгмийн бодлогын удирдлагын үйл ажиллагааг иргэдэд хүргэх, төрийн захиргааны удирдлагыг тасралтгүй хэрэгжүүлэх чиг үүрэгтэй.
- Корона вирус -2019 цар тахлаас урьдчилан сэргийлэх, цаг агаарын хүндрэл, малын халдварт шүлхий өвчинтэй тэмцэх хөл хорио тогтоосны улмаас байнгын бэлэн байдалд, тасралтгүй үйл ажиллагаа явуулж орон нутагт онцгой комиссын чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа болно.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.
Бусад мэдээлэл болох гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан, худалдан авах ажиллагааны тайлан нь санхүүгийн бус мэдээллийг агуулсан тул санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудит хийхэд баримтлах ерөнхий бодлого, чиглэлийн дагуу Төсвийн тухай хуулийн 25.5-д заасан тохиолдолд хандив тусламж авсан эсэх, Өндөр настны тэтгэвэр тогтоолгосон ажилтны оронд нөхөн томилгоо хийсэн эсэх асуудлуудыг тусгайлан авч үзэж, үр дүнг тайлагнахаар энэхүү төлөвлөгөөнд тусгасан.

Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтмол зардал, шатахуун, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал, үндсэн хөрөнгө дансдыг түүвэрлэн үзэж горим сорил хэрэгжүүлэхэд

Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын засаг даргын Тамгын газар нь малчдад өвс, тэжээл хүргэх, цаг агаарын хүндрэлтэй байдлыг давахад зориулж сумын иргэдээс 2021 онд 3.3 сая төгрөгийн хандив, тусламж нэмэлт санхүүжилтийн дансанд орсон ба санхүүгийн тайланд тайлагнасан байна. Тайлант онд өндөр настны тэтгэвэр тогтоолгосон ажилтан гараагүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан.

Байгууллагын 2021 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээллэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn цахим хуудсанд ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хөвсгөл аймгийн Улаан-уул сумын Засаг даргын Тамгын газар нь нийт мэдээлбэл зохих 424.5 сая төгрөгийн 65 мэдээллээс 372.3 сая төгрөгийн 62 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна. цалингийн зардлаас буад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй 34.2 сая төгрөгийн орлогын гүйлгээний 1 мэдээлэл байршуулаагүй, 137.8 цалингийн зардлаас буад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлогын 4 гүйлгээний 137.8 сая төгрөгийн орлогын

гүйлгээ, 17.9 сая төгрөгийн зарлагын 2 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6.1.5, 6.4.5 дугаар заалтууд, МУЕА-ын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан чиглэлтэй нийцэхгүй байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрөөс 3.6 сая төгрөгийг баяр, ёслол, урлагийн наадам, тэмцээний үйл ажиллагааг санхүүжүүлсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.6-д "*Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн ... зэргийг зохион байгуулахгүй байх*" гэсэн заалттай нийцэхгүй байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлж ажилласан байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал илрээгүй болно.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 193.5 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 193.5 сая төгрөгийн 2 зөвлөмж өгсөн болно.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой алдаа илрээгүй болно.

### 4.2 Төлбөрийн акт

Тус байгууллагын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

### 4.3 Албан шаардлага

Албан шаардлага хүргүүлээгүй болно.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

1.1. <u>*Илрүүлэлт:*</u> Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийг авч үзэхэд www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлбэл зохих 424.4 сая төгрөгийн 65 мэдээллээс 268.7 сая төгрөгийн 51 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж 34.2 сая төгрөгийн 1 мэдээлэл байршуулаагүй, 155.7 сая төгрөгийн 12 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна.

1.2. *Өгсөн зөвлөмж:* Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4."*Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ*"-т заасан мэдээллийг тухай бүр шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлж байх.

**2. *Төсвийн хэмнэлттэй холбоотой асуудал***

<u>2.1</u> <u>*Илрүүлэлт:*</u> Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрөөс 3.6 сая төгрөгийг баяр, ёслол, урлагийн наадам, тэмцээний үйл ажиллагааг санхүүжүүлсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.6-д "*Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн...зэргийг зохион байгуулахгүй байх*" гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2 *Өгсөн зөвлөмж:* Тайлант онд батлагдсан төсвийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Улаан-уул сумын Засаг даргын Тамгын газар | 2 | 193.5 | | | | | | | 2 | 193.5 |

БАТАЛГААЖУУЛАЛТ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:
АУДИТЫН МЕНЕЖЕР Э.БАТ-ЭРДЭНЭ ОГНОО: 2022.02.22

БАТАЛГААЖУУЛСАН:
АХЛАХ АУДИТОР Д.ОТГОНБАЯР ОГНОО: 2022.02.22

## АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДЛЫН БҮРТГЭЛ

Байгууллагын нэр:

Тайлант хугацаа: 2021 оны Санхүүгийн тайлангийн аудит

2/7/2022

*Төгрөгөөр*

| № | Ажил үйлчилгээний анги, дансны үлдэгдэл тодруулга | Алдаа зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Шалгагдагч байгууллагын санал, тайлбар | Аудитын байгууллагаас өгсөн хариу, тайлбар | Гаргасан шийдэл | Шалгагдагч байгууллагын холбогдох хүний: Албан тушаал | Овог нэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| 1 | Төсвийн зарцуулалт | Засгийн газрын 43 дугаар тогтоол, Аймгийн Санхүү,Төрийн сангийн даргын 2021 оны 04 сарын 21-ний өдрийн 8/907 тоот албан бичгийн хэрэгжилттэй нийцэхгүй байна. | 3,600,000.00 | Зөвлөмж өгөх | Улаан-Уул сумын ЗДТГ-ын хэмнэлт гаргаагүй нь тухайн тайлант онд ковид-19 цар тахалтай тэмцэх, хаврын олон удаагийн их хэмжээний цас, малын гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн олон төрлийг ажлууд ыг хийж гүйцэтгэсэн. Жич: 2021 оны 01 сарын 01-ны өдрөөс 2021-07-09-ны өдөр хүртэл 6 сар 9 хоног хөх эргийн нэвтрэх цэг, постыг 24 цагийн турш ажлуулж байсан. 2021-04-08-2021-04-22-ны хооронд 3 удаагийн их хэмжээний нойтон цас орж сумын хэмжээнд малын хорогдол ихсэж мал өлгүйдэх аюул үүсэхэд Эрдэнэбулган сумаас Паб маркын чиргүүлтэй 2 авто машинаар 4-н тэвш 1100 ширхэг присс ачиж ирж ирсэн. Мөн 2021 оны 12 дугаар сард малын шүлхий өвчин гарч сэлэнгэ аймгаас шүлхийн ариутгалын бодис эм тариаг бэлтгэж тоом багт 2 хяналтын постыг 2021-12 18-2022-02-22-ны байдлаар ажиллуулж байна. Дээрх байгалийн болон, халдварт өвчинтэй тэмцэх ажлууд ыг хийж гүйцэтгэхээс аргагүй ажлууд ар араасаа гарч байсан он байлаа. | | Илэрсэн алдаа зөрчлийг давтан гаргахгүй ажиллах хүсэлт хүргүүлж байна. | ЗДТГ-ын нягтлан бодогч | Б.Цэвээнравдан |
| 2 | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт | Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тайлагнаагүй, 34.3 сая төгрөгийн 1 мэдээлэл байршуулаагүй, 17.9 сая төгрөгийн 2 мэдээллийг хугацаа хоцроосон нь шилэн дансны тухай хуулийн 6.1.5, 6.4.5 дугаар заалтууд, МУЕА-ын 2021 оны А/108 дугаар тушаалаар батлсан чиглэлтэй нийцэхгүй байна. | 189,900,000.00 | Зөвлөмж өгөх | Шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь шилэн дансны тухай хуулийн 6.1.5, 6.4.5 дугаар заалтыг зөрчиж байгаа нь УБ хотруу эмнэлгийн ажлаар явах үед болон мөрөнгийн халдварын эмнэлэгт 14 хоног хэвтэн эмчлүүлэх, гэрийн хорионд 14 хоног байх зэрэг 2 сарын хугацаанд ар гэрийн асуудлууд байсан. | | Илэрсэн алдаа зөрчлийг давтан гаргахгүй ажиллах хүсэлт хүргүүлж байна. | Нягтлан бодогч | Б.Цэвээнравдан |
| Дүн | | | | | | | | | |

БЭЛТГЭСЭН:
АХЛАХ АУДИТОР Д.ОТГОНБАЯР

ХЯНАСАН:
МЕНЕЖЕР Э.БАТ-ЭРДЭНЭ

ТАНИЛЦАЖ ЗӨВШӨӨРСӨН: УЛААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА М.БАТЦОГТ

НЯГТЛАН БОДОГЧ: Б.ЦЭВЭЭНРАВДАН

РНА0002